Харин сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 156971.1 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд 11 иргэнд 69000.0 мянган төгрөгийн зээл шинээр олгож 42224.4 мянган төгрөгийн зээлийг барагдуулж оны эцэст 186746.7 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүний насжилтаар авч үзвэл 2013 онд олгосон 5 зээлдэгчийн 7674.3 мянга, 2014 онд олгосон 1 зээлдэгчийн 8512.3 мянга, 2015 онд олгосон 3 зээлдэгчийн 11158.4 мянга, 2017 онд олгосон 16 зээлдэгчийн 15423.6 мянга, 2019 онд олгосон 13 зээлдэгчийн 72910.5 мянга, 2020 онд олгосон 11 зээлдэгчийн 68097.5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд хугацаа хэтэрсэн 10 зээлдэгчийн 37491.2 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байна.

Засаг даргын Тамгын газар тайлант онд 4000.0 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна. Энэ нь 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар " "Элэг нэгтэн" ХХК-д "Цэрэг толгой" -д угталт, үдэлтийн хаалганы ажлыг гүйцэтгэхээр 2020.07.24-нд 8000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2020.08.11-нд бараа үйлчилгээний бусад зардлаас 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж ажлыг хийгээгүй тул тайланд авлагаар тусгаж залруулсан байна.

Хүүхдийн цэцэрлэг нь оны эхэнд авлагагүй байсан бөгөөд тайлант хугацаанд 10620.0 төгрөгийн нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг шилжүүлж хөрөнгө аваагүй авлага үүсгэсэн байна.

Ерөнхий боловсролын сургууль цахим самбарын үнэнд 9885.0 мянган төгрөг шилжүүлж хөрөнгө орлого аваагүй авлага үүсгэсэн байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 186211.4 мянга, эцсийн үлдэгдэл 273266.1 төгрөг болж,

87054.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	11,430.9	29,587.8	18,156.8
Эм боох материал	0.0	610.0	610.0
Бичиг хэргийн материал	2,803.5	3,896.6	1,093.2
Аж ахуйн материал	44,599.5	49,433.4	4,834.0
Түлш, шатах тослох материал	237.1	1,037.1	0.0
Барилгын засварын материал	459.0	459.0	0.0
үнсний материал	2,398.8	529.2	-1,869.6
Бусад хангамжийн материал	113,299.6	114,114.2	814.6
Мал амьтад	7,096.0	4,065.0	-3,031.0
Нөөцийн бараа	3,887.0	69,533.8	65,646.8
Дүн	186,211.4	273,266.1	86,254.7

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Бараа материалын дансны үлдэгдэл 203732.3 мянган төгрөг болж өмнөх оноос 21407.9 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн бараа материалын үлдэгдэл 22639.0 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	3,857.5	3,857.5	-	1.4
ЗДТГ	65,094.3	110,150.2	45,055.9	40.3
Сургууль	31,519.7	38,558.8	7,039.1	14.1
Цэцэрлэг	31,450.1	40,662.2	9,212.2	14.9
Эрүүл мэндийн төв	41,296.9	63,936.0	22,639.0	23.4
Соёлын төв	12,992.8	16,101.3	3,108.5	5.9
Орон нутгийн хөгжлийн сан	-	-	-	-
НИЙТ ДҮН	186,211.4	273,266.1	87,054.7	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 340018.8 мянган төгрөгийн бараа материалын 214222.6 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 17077.1 төгрөгийн материал шилжүүлэн авсан, хандиваар 108512.1, бусад байдлаар 207.0 мянган төгрөг нэмэгдсэн байна. Тайлант онд ИТХ 3857.5 мянга, Засаг даргын Тамгын газар 104654.6 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсан, Эрүүл мэндийн төв 17077.1 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	340,018.8	Хасагдсан	252,964.1
Худалдан авсан	214,222.6	Худалдсан, зарцуулсан	213,464.5
Шилжүүлэн авсан	17,077.1	Шилжүүлсэн	35,341.6
Хандиваар	108,512.1		0.0
бусад	207.0	бусад	4,158.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3823784.4 мянга, эцсийн үлдэгдэл 4026075.1 мянган төгрөг болж, 202290.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	3,764,587.8	3,967,321.1	202,733.2	98.5
Барилга байгууламж, орон сууц	2,681,151.4	2,817,985.1	136,833.7	70.0
Тээврийн хэрэгсэл	175,724.8	231,224.8	55,500.0	5.7
Машин тоног төхөөрөмж	496,134.4	511,557.4	15,423.0	12.7
Тавилга эд хогшил	308,423.3	315,759.5	7,336.2	7.8
Түүх соёлын дурсгалт зүйл	245.9	245.9	-	0.0
Дуусаагүй барилга байгууламж	21,400.0	7,400.0	(14,000.0)	0.2
Номын фонд	34,766.5	36,406.8	1,640.3	0.9
Бусад үндсэн хөрөнгө	46,741.5	46,741.5	-	1.2
ИЕТ БУС ХӨРӨНГӨ	59196.6	58754	-442.6	1.4
Программ хангамж	3092.6	2650	-442.6	0.1
Бусад биет бус хөрөнгө	56104	56104	0	1.4
НИЙТ ДҮН	3,823,784.4	4,026,075.1	202,290.6	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 202920.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 94.4 хувь буюу 191597.0 мянган төгрөгийг хөрөнгийн хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна Үүнд: 9 жилийн сургуульд НҮБ-ийн Олон улсын төслийн хөрөнгөөр халуун усны барилга-103530.9 мянга, Эко нойл-9990.7 мянга, Засаг даргын Тамгын газарт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн цэцэрлэгт хүрээлэн 20000.0 мянга, аймгийн Засаг даргын Тамгын газраас тоног төхөөрөмж 9262.4 мянга, Цэцэрлэгт БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар зөөврийн компьютер-5248.5 мянга нийт 148032.6 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн авсан байна.

Мөн эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн яамнаас фургон автомашин 31500.0 мянга, Ерөнхий боловсролын сургуульд БСШУЯ-аас зөөврийн компьютер 3586.4 мянга, проектор 1041.8 мянга, тавилга эд хогшил 5186.3 мянган төгрөгийн хөрөнгүүдийг тус тус нэмэгдсэнийг хандиваар бүртгэж тайланд тусгасан байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	12,964.3	13,964.3	1,000.0	0.3
Засаг даргын Тамгын газар	1,921,012.9	1,964,687.3	43,674.4	48.8
Соёлын төв	102,340.2	103,920.1	1,579.9	2.6
Эрүүл мэндийн төв	281,442.8	312,742.8	31,300.0	7.8
Ерөнхий боловсролын сургууль	1,078,790.7	1,194,738.5	115,947.8	29.7
Хүүхдийн цэцэрлэг	427,233.6	436,022.1	8,788.5	10.8
НИЙТ ДҮН	3,823,784.4	4,026,075.1	202,290.6	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тухайн онд 38716.2 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 43564.4 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 148032.6 мянган төгрөгийг шилжүүлэн авсан айна

Мөн ашиглалтгүй болсон программ хангамжийг аймгийн ИТХ-ын тогтоолоор ЗДТГ 500.0 мянга, Соёл 200.0 мянга, эрүүл мэндийн төв 200.0, ерөнхий боловсролын сургууль 422.6 мянга, хүүхдийн цэцэрлэг 200.0 мянган төгрөгийн тус тус акталсан байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	230,313.2	Хасагдсан	28,022.6
Худалдан авсан	38,716.2	Худалдсан	0.0
Хандиваар	43,564.4	Акталсан	1,522.6
Шилжүүлэн авсан	148,032.6	Шилжүүлсэн	14,000.0
бусад		Бусад	12,500.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 7350.6 мянга, эцсийн үлдэгдэл 17892.1 мянган төгрөг болж 10541.5 мянган төгрөгөөр өссөн байна

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	7,350.6	17,892.1	10,541.5	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	142.6	371.0	228.4	2.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг		30.5	30.5	0.2
Байгууллагад төлөх өглөг	6550.0	17453.6	10903.6	97.5
Хувь хүмүүст төлөх өглөг	658.0	37.0	-621.0	0.2
Дүн	7,350.6	17,892.1	10,541.5	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 17892.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 17390.3 хувь буюу 97.2 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна. Энэ цагийн үеийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор 17390.3 мянган төгрөгийн өвс тэжээлийг авч өглөг үүссэн байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	1058	0	-1058	0.0
Соёлын төв	142.59	130.8	-11.79	0.7
Эрүүл мэндийн төв	0	176.61	176.61	1.0
ОНХС	6000	17390.3	11390.3	97.2
Цэцэрлэг	150.0	194.3	44.337	1.1
НИЙТ ДҮН	7,350.6	17,892.1	10,541.5	100.0

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4768266.7 мянга, эцсийн үлдэгдэл 4818530.2 мянган төгрөг болж, 50263.5 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,578,564.0	1,578,564.0	0.0	32.8
Өмч: - төрийн	1,578,564.0	1,578,564.0	0.0	32.8
Хуримтлагдсан үр дүн	413,132.1	463,395.6	50,263.5	9.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,198,006.5	1,198,006.5	0.0	24.9
Дүн	4,768,266.7	4,818,530.2	50,263.5	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс 50263.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 50263.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.16-ний өдрийн хуралдаанаар 12/03 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 74160.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3000.0 мянга, нийт 77160.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.10.30-ны өдрийн 1/05 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 35685.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгон татварын орлогыг 47560.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3100.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	47,560.00	49,709.12	-2,149.12	104.5
ИОТХ	5,000.00	11,737.50	-6,737.50	234.8
Бууны татвар	1,800.00	1,380.00	420.00	76.7
Улсын тэмдэгтийн хураамж	1500	747.70	752.30	49.8
Хадгалмжийн хүүгийн орлого	30,000.00	33,032.57	-3,032.57	110.1
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	900.00	900.00	0.00	100.0
Газрын төлбөр	1,360.00	199.35	1,160.65	14.7

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.00	1,312.00	4,688.00	21.9
ТТАМ-ын нөөц ашигласны төлбөр	1000	400	600.00	40.0
2.Татварын бус орлого	3,100.00	8,085.00	-4,985.00	260.8
2.1.Хүү торгуулийн орлого	3,100.00	8,085.00	-4,985.00	260.8
Нийт дүн	50,660.00	57,794.12	-7,134.12	114.1

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 2149.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон хувь хүний орлогын албан татварын орлого, хадгаламжийн хүүгийн орлогыг давуулан биелүүлсэн ба бусад албан татварууд 14.7-76.7 хувийн биелэлттэй байна.

Иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон хувь хүний орлогын албан татвар 5000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж гүйцэтгэлээр 11737.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Энэ нь 2020 оны 12 дугаар сард “Эрдэнэс таван толгой” ХК-ны ногдол ашгийн орлогын суутган татвараас шалтгаалсан байна.

Харин бууны албан татвар 76.7 хувь буюу 420.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 49.8 хувь буюу 752.3 мянга, газрын төлбөр 14.7 хувь буюу 1160.7 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 21.9 хувь буюу 4688.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 40 хувь буюу 600.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 840.0 мянга, ерөнхий боловсролын сургууль 1000.0 мянган төгрөгийн орлогоос 300.0 мянга, соёлын төв 1000.0 мянган төгрөгийн орлого төлөвлөж орлого ороогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 65289.1 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 46460.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2086347.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1963300.3 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 1863945.9 урсгал зардалд зарцуулсан бол 123047.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.12.16-ний өдрийн 12/03 дугаар тогтоолоор нийт 2153152.9 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	75,594.9	86,543.5	10,948.6
Засаг даргын Тамгын газар	450,095.5	460,455.7	10,360.2
Сургууль	506,083.7	630,325.4	124,241.7
Цэцэрлэг	275,696.9	269,588.6	(6,108.3)
Эрүүл мэндийн төв		387,593.0	387,593.0
Соёлын төв	171,021.0	78,211.5	(92,809.5)
Сум хөгжүүлэх сан		99,957.1	99,957.1
Орон нутгийн хөгжлийн сан		140,478.1	140,478.1
Нийт дүн	1,478,492.0	2,153,152.9	674,660.9

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.16-ний өдрийн 12/03 дугаар тогтоолоор анх баталсан 2153152.9 мянган төгрөгийг 2020.10.30-ний өдрийн 1/05 дугаар тогтоолоор 35685.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 17350.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.30-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 48470.0 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2086347.8 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1097865.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 75607.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 623329.0 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 50660.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 102498.1 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 17756.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 118632.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 4688.0 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 15143.4 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 36804.7 мянга, орон нутгийн төсөвт 16328.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	ОН төсөвт төвлөрүүлсэн
ИТХ	85,171.4	84,977.0	194.4	99.8		194.4
ЗДТГ	44,455.7	438,552.3	4,903.4	98.9		55.4
Сургууль	609,687.5	563,706.9	45,980.6	92.5	33,960.9	11,319.7
Цэцэрлэг	252,235.6	247,827.2	4,408.4	98.3	2,829.8	1,578.6
Соёлын төв	79,711.5	75,547.5	4,164.0	94.8		3,164.0
Хүн эмнэлэг	383,813.0	383,771.5	41.5	100.0	14.1	16.2
СХСан	99,957.1	69,572.5	30,384.6	69.6		
ОНХСан	132,316.0	99,345.4	32,970.6	75.1		
Нийт дүн	2,086,347.8	1,963,300.3	123,047.5	94.1	36,804.8	16,328.3

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1963300.3 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулиудын урсгал зардлыг 45980.6 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 32970.6 мянга, сум хөгжүүлэх сангийн зардлыг 30384.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 16. Хүрээмарал сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,086,347.8	1,963,300.3	123,047.5	94.1
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	85,171.4	84,977.0	194.4	99.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	70,181.2	70,101.2	80.0	99.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,100.0	2,100.0	0.0	100.0
80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал	11,126.2	11,126.2	-	100.0
82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	1,764.0	1,649.6	114.4	93.5
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	443,455.7	438,552.3	4,903.4	98.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	304,955.6	304,076.5	879.1	99.7
80106 Баг, хорооны ҮАЗардал	65,875.4	65,822.5	52.9	99.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	55,343.4	55,343.3	0.1	100.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	12,000.0	11,998.0	2.0	100.0
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	5,281.3	1,312.0	3,969.3	24.8
70503 Орон нутгийн зорилтот ХОруулал	132,316.0	99,345.4	32,970.6	75.1
80904 Нийгмийн зориулалттай барилга	132,316.0	99,345.4	32,970.6	75.1
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	383,813.0	383,771.5	41.5	100.0
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	20,939.4	20,923.2	16.2	99.9

80302 Нэг иргэнд ногдох нормативаар	15,222.0	15,222.0	0.0	100.0
81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	347,651.6	347,626.3	25.3	100.0
71702 Соёл урлаг	79,711.5	75,547.5	4,164.0	94.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	75,653.2	72,725.2	2,928.0	96.1
80214 Уран бүтээл хийлгэх	1,500.0	330.0	1,170.0	22.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,558.3	2,492.3	66.0	97.4
71801 Сургуулийн өмнөх боловсрол	252,235.6	247,827.2	4,408.4	98.3
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	23,401.9	21,823.3	1,578.6	93.3
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	84.5	-	84.5	-
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	13,344.0	15,325.2	(1,981.2)	114.8
81833 Явуулын багшийн үйлчилгээ	5,203.7	4,590.5	613.2	88.2
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	179,268.4	175,421.2	3,847.2	97.9
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	30,933.1	30,666.9	266.2	99.1
71802 Ерөнхий боловсрол	600,728.1	555,257.4	45,470.7	92.4
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	84,773.1	73,453.4	11,319.7	86.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,355.8	-	1,355.8	-
81801 үдийн цай хөтөлбөр	10,373.4	7,304.4	3,069.0	70.4
81806 Дотуур байрны үйлчилгээ	85,530.4	68,092.1	17,438.3	79.6
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	299,429.8	291,233.0	8,196.8	97.3
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	119,265.6	115,174.5	4,091.1	96.6
71806 Насан туршын болон албан бус боловсрол	8,959.4	8,449.5	509.9	94.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	8,959.4	8,449.5	509.9	94.3
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	99,957.1	69,572.5	30,384.6	69.6
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	99,957.1	69,572.5	30,384.6	69.6

Эх сурвалж: :Хүрээмарал сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4 байгууллага 70929.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 3 байгууллага 13567.7 мянга, нийт 84497.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 23476.7 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 28470.9, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 18449.4 мянган нийт 70397.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 14100.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 17. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	9,956.70	27,780.50	25,535.10	21,224.70	84,497.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө					0.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,956.7	14,377.2	25,535.1	21,060.3	70,929.3
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		13403.3		164.4	13,567.70
НИЙТ ЗАРЛАГА	8,356.70	15,280.50	25,535.10	21,224.70	70,397.00

Бараа, ажил үйлчилгээний зардал	8,356.70	903.3	9,189.40	18,449.40
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		5815.6	17,661.10	23,476.70
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,561.60	7874	12,035.30
Төсөвт төвлөрүүлсэн	1,600.00	12,500.00	0.00	0.00
				14,100.00

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 18. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	9	-	
2	Хагас жил	3	3	3	-	
3	Улирал бүр	2	8	8	-	
4	Сар бүр	5	60	60	-	
5	Тухай бүр	6	72	69	3	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтын хэмжээ 7,9 сар, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 2 сарын мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан.
НИЙТ		30	155	149	3	

Эх сурвалж. Хүрээмарал сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 байгууллагын санхүүгийн тайланд түүвэрт хамруулж 1 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан 4 байгууллагаас "Зөрчилгүй" 3, "Хязгаарлалттай" 1 санал дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 19. Хязгаарлалттай болон авсан байгууллагууд

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	" Байгууллагын даргын 2020.12.15-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисс байгуулахдаа бүрэлдэхүүнд нь нярвыг оруулсан, санхүүгийн тайланд үлдэгдлээр байгаа бараа материалаас 15670.0 мянга, үндсэн хөрөнгөөс 60967.8 мянга, нийт 76637.8 мянган төгрөгийн бүртгэлтэй хөрөнгийг тооллогын комисс тоолоогүй, нягтлан бодогч тооцоо акт үйлдээгүй; Байгууллагын нярав, нягтлан бодогч нар хөрөнгийг авсан тухай бүрд орлогод авдаггүй, авсан хугацаанаас хойш төлбөрийг шилжүүлэхдээ нярвын тайланг гаргаж, санхүүгийн программд бүртгэн нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөөгүй, нярав бараа материалын тайланг гаргахдаа эхний үлдэгдлийг материал тус бүрээр гаргалгүй бөөн

дүнгээр гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж байгууллага, нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөнө" 5 дугаар зүйлийн 5.1.4. Үнэн зөв байх" гэсэн заалт, Үнэн зөв байдал, толилуулга бай тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 41251.7 мянган төгрөгийн 16 алдаа, зөрчил илэрснээс 4570.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17075.0 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 14007.0 мянган төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 заалт бүхий зөвлөмж өгч, 5600.0 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулжээ. /Хавсралт 2./

Хүснэгт 20. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил

Байгууллагын нэр	нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Санхүүгийн тайланд залруулсан	
	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
ЗДТГ	5	19261.7	1	4000	2	13862	2	1400		
ЕБС	7	15333.3	2	569.9	2	3213.2	1	9885.0	2	1665
Хүүхдийн цэцэрлэг	4	5454.3					2	1520	2	3934
Эрүүл мэндийн төв	2	1202.4					2	1202.4		
Нийт дүн	18	41251.7	3	4570	4	17075	7	14007	4	5600

Хүрээмарал сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 42707.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5216.4 мянган төгрөгийг 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 37491.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайланг Э-тайланд нэгтгэхдээ үр дүн, мөнгөний гүйлгээний тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогыг 1284.0 мянган төгрөгөөр илүү аудитлагдсан санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн 3932.3 мянган төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг Э тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгээгүй хүүгийн орлогоор бүртгэсэн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр сумын Санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Сумын Эрчим хүчинд ашиглаж байсан 35990.0 мянган төгрөгийн өртөгтэй япон улсад үйлдвэрлэгдсэн моторыг 2011 оны 4 сард "Шижир аранжин" ХХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулахаар тухайн үед Сумын Засаг даргаар ажиллаж байсан Ц.Сэмжиддоржтой гэрээ байгуулсан байна. Моторын түрээсийн авлага 3066.8 мянган төгрөг санхүүгийн тайланд авлагаар тусгасан. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч одоо болтол барагдуулаагүй байна.

Мөн дээрх 35990,0 мянган төгрөгийн өртөгтэй моторыг Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2019.01.04-ны өдрийн А/09 тоот албан бичгээр сумын ИТХТ-ээр хэлэлцүүлэн актлах

шийдвэр өгсний дагуу Хүрээмарал сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.03.29-ны өдрийн 07 дугаар тогтоолоор акталж данснаас хасах шийдвэр гаргасны дагуу 2019 онд данснаас хассан байгаа тул энэ асуудлыг цаашид анхаарч завсрын аудитаар үзэх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.1.1. Илрүүлэлт: Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 1 байгууллага “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.1.2. Эрсдэл: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэлд сумын Төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад санхүүгийн албаны дарга тавьж байгаа дотоод хяналтаа сайжруулах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.2.2 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийн хугацаа болоогүй байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

4.2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.3.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн 183449.3 мянган төгрөгийн үлдэгдлээс 10 зээлдэгчийн 37491.2 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл нь

2013-2017 онуудад олгосон гэрээ хугацаа дуусаж хэтэрсэн байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.7 "Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна

4.3.2. **Эрсдэл:** Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох, авлага найдваргүй болох, орлогын төлөвлөгөө тасрах.

4.3.3 **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 10 зээлдэгчийн 37491.2 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

4.3.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР

Н.БҮНЧИНСҮРЭН 2021.03.25

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.03.25



5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Хүрээмарал сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/15/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Хүрээмарал сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайланг Э тайланд нэгтгэхдээ үр дүн, мөнгөний гүйлгээний тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогыг 1284.0 мянган төгрөгөөр илүү аудитлагдсан санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна.	1284.0	Санхүүгийн тайланд залруулга хийх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	С.Сумъяабазар С.Нархүү
2	Сум хөгжүүлэх сангийн 3932.3 мянган төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг Э тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгээгүй хүүгийн орлогоор бүртгэсэн байна.	3982.3	Санхүүгийн тайланд залруулга хийх	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	С.Сумъяабазар С.Нархүү
3	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 1 байгууллага "Хязгаарлалттай" дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.		Зөвлөмж өгсөн	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	С.Сумъяабазар С.Нархүү
4	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийн хугацаа болоогүй байна		Зөвлөмж өгсөн	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	С.Сумъяабазар С.Нархүү
		5266.3			

oOo

6. Хавсралт 2.: Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Ерөнхий боловсролын сургууль		15,333.3			
1	Оны эцэст эд хөрөнгийг бүрэн тоолоогүй, бараа материалын тайланг бүрэн гаргаагүй, бараа материал, үндсэн хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн, орлогыг төсөвт төвлөрүүлээгүй зарцуулсан.	3,213.2	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл
2	Шилэн дансны нэгдсэн системд 2020 оны худалдан авах ажиллагааны тайлангийн гэрээний дүнг 2021 оны гэрээний дүнгээр мэдээлж, 23767.9 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн; байгууллагын даргын 15485.9 мянган төгрөгийн 3 тушаалыг шилэн дансанд мэдээлээгүй, төсвийн захирагч утасны дугаар өөрчлөгдсөн байхад мэдээллийг өөрчилж оруулаагүй байна.	-	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл
3	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 500.0 мянган төгрөгөөр ажиллагсад ажлын өмд, цамц авч төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	500.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл
4	Байгууллагын тогооч Ж.Уранбилэгт 69.9 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.	69.9	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл
5	Оны эцэст төсөвт 10000.0 мянган төгрөгөөр тодотгол хийж, 9885.0 мянган төгрөгийн цахим хичээлийн ухаалаг самбар нийлүүлэх гэрээг "Дэвших болор" ХХК-тай гэрээ байгуулж, авлагаар тусгасан ба 2021 оны 02 дугаар сард хөрөнгийг хүлээн авсан байна.	9,885.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл
6	Байгууллагын нягтлан бодогч түрээсийн сурах бичгийн орлогын 541.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дээд шатны төсвийн захирагчаас авсан санхүүжилтээр буруу тайлагнаж, сургуулийн халуун усны орлогоор 300.0 мянган төгрөг оруулсныг нягтлан бодогч үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор, мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.	841.2	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл
7	Ажиллагсад олгосон цалинг нийгмийн даатгалын мэдээнд ажилтны кодыг буруу мэдээлсэн, 2020 оны 8, 9, 10 дугаар сарын нийгмийн даатгалын мэдээний эхний, эцсийн үлдэгдэл зөрүүтэй, 12 дугаар сарын мэдээнд тооцоогүй байхад санхүүгийн тайланд 143.1 мянган төгрөгийн авлага тусгасан байна.	824.0	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр, Д.Оюунгэрэл
Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газар		19,261.7			
1	"Элэг нэгтэн" ХХК-д "Цэрэг толгой"-д угталт, үдэлтийн хаалганы ажлыг гүйцэтгэхээр 2020.07.24-нд 8000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2020.08.11-нд бараа үйлчилгээний бусад зардлаас 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж ажлыг хийгээгүй тайланд авлагаар тусгасан байна.	4,000.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр

A	2	3	4	5	6
2	Сумын Засаг даргын 2020.07.22-ны өдрийн А/77 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс лам нарын унааны болон байр, хоолны зардалд 1400.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1,400.0	Зөвлөмж өгсөн	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
3	2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3066.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч одоо болтол барагдуулаагүй байна.	3,066.9	Албан шаардлага өгсөн	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
4	Мал эмнэлгийн үржлийн тасгийн 2017 онд ашиглалтад орсон 2494.8 мянган төгрөгийн өртөгтэй 1 мотоцикль, багийн дарга нарын 2018 онд ашиглалтад орсон 1660.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 ширхэг мотоцикль улсын бүртгэлийн гэрчилгээ байхгүй байна	10,794.8	Албан шаардлага өгсөн	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
5	Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл байна	-	Зөвлөмж өгсөн	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
	Хүүхдийн цэцэрлэг	5,454.3			
1	Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ Тулга Техник ХХК-д шилжүүлээд авлагаар бүртгэсэн.	1,520.0	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
2	27 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
3	5 төрлийн 3740,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тусгай зориулалтын бараа материал дансанд бүртгэсэн байна.	3,740.0	Санхүүгийн тайланд залруулсан	Эрхлэгч Нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
4	Цалингийн зардлыг санхүүгийн тайланд 194.3 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, ХХОАТатварын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй тохируулах бичилтээр хааж бичсэн.	194.3	Санхүүгийн тайланд залруулсан	Эрхлэгч Нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
	Эрүүл мэндийн төв	1,202.4			
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдаагүй салбарын онцлогийг тусгаагүй		Зөвлөмж өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Г.Байгалмаа Б.Мэндбаяр
2	Аймгийн ЭМГ-аас 12913,1 мянган төгрөгийн тендерийн бус эм, боох материал хувиарилсан боловч эргэлтийн эмийн сан11710,7 мянган төгрөгийн эм хүлээн авч, 1202,4 төгрөгөөр зөрүүтэй байна.	1,202.4	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Г.Байгалмаа Б.Мэндбаяр
	Нийт дүн	41,251.7			

оОо